

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГИЙН



ШИНЭ ХӨДӨӨ ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД: БУА-2021/05-ШТА-ГА

Шинэ хөдөө төслийн хэрэгжилт хангалтгүй,
зорилтод түвшинд хүрч ажиллаагүй, үр
дүнгүй хэрэгжсэн байна.

БУЛГАН АЙМАГ 2021 ОН

Булган аймаг дахь Төрийн аудитын газрын
Дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр
Утас: 70342580 Цахим хаяг: Ankhubayard@audit.gov.mn
Аудитын менежер Ж.Энхцоодол
Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn
Ахлах аудитор П.Мөнхтуяа
Утас: 70342716 Цахим хаяг: MonkhtuyaP@audit.gov.mn
Аудитор Б.Энхтөр
Утас: 70342716 Цахим хаяг: Enkhturb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой
мэдээллийг дараах хаягаар авна уу.
Цахим хуудас www.audit.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	3
Хүснэгтийн товьёг	4
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	5
БҮЛЭГ А. Аймагт хэрэгжих төсөл арга хэмжээг төлөвлөхдөө сум, иргэдийн нэн тэргүүнд шаардлага үүссэн тоног төхөөрөмж болон мэргэжилтний судалгааг оновчтой гаргаж ажиллаагүй байна	6
А.1. Шинэ хөдөө төслийн хүрэх үр дүн, зорилтыг төлөвлөж тооцоо судалгаа гаргаж дүгнэж төлөвлөжээ	6
А.2 Орлогыг 1553.6 мянган төгрөгөөр дутуу төлөвлөж, анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангаж ажиллаагүй, орлогын гүйцэтгэл 17 хувьтай байна	6-7
А.3 Тендерийг хууль журмын дагуу зохион байгуулан ажилласан ч гүйцэтгэгчийг шалгаруулахдаа өмнөх ажлын үр дүнг тооцож ажиллах шаардлага үүсэж байна	8
Б.Шинэ хөдөө төслийн хүрээнд хийгдсэн арга хэмжээ, үйл ажиллагаа нь үр дүн бага байна	8
Б.1. Түрээсийн гэрээ хийсэн иргэн эргэн төлөлтөө хугацаандаа хийгээгүй, иргэнтэй гэрээ хийж ажиллаагүй, авлага 13 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь найдваргүй авлага үүсэх магадлалтай байна	8-9
Б.2. Шинэ хөдөө төслөөр хэрэгжсэн төслийн үр дүн, ашиг шимийг тооцож ажиллаагүй, ИТХ-ын тогтоол, шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй, одоог хүртэл ашиглагдаагүй тоног төхөөрөмжүүд байгаа нь төсөл үр дүнгүй байна	9-13
В. Бүлэг: Сумдаас төслийн хүрээнд хийгдсэн ажлын тайлан мэдээг цаг хугацаанд нь авч дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна	13
В.1 “Шинэ хөдөө-хөгжил” ОНӨААТҮГ нь үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш төслийн хүрээнд хийгдсэн ажлын тайлан мэдээг сумдаас хүлээн авч ажиллаагүй байна	13-14
В.2 Хяналт шалгалтаар илэрсэн алдаа зөрчил одоог хүртэл шийдвэрлэгдээгүй, арилаагүй байна	14
В.3 Хяналт шалгалтын байгууллагаас өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг тооцож байгаа ч бүрэн хэрэгжүүлээгүй байна	14
ДҮГНЭЛТ	14-15
ЗӨВЛӨМЖ	15

Товчилсон үгийн тайлбар

ХХААГ	Хүнс хөдөө аж ахуйн газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ХТҮА	Хот тохижилт үйлчилгээний алба
ОУНББ	Олон улсын нягтлан бодох бүртгэл
ХААХИ-ОНӨХХК	Хөдөө аж ахуй хөгжлийн ирээдүй орон нутгийн өмчит хариуцлагатай хувьцаат компани

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Шинэ хөдөө төслийн санхүүжилтийн тоон мэдээлэл	8
Хүснэгт 2	Төлөвлөгөө, гүйцэтгэлийн харьцуулалт	8
Хүснэгт 3	Гэрээ хийгдээгүй тоног төхөөрөмжийн тоон мэдээлэл	9-10
Хүснэгт 4	Байгаль хамгаалах сангаас олгосон санхүүжилтийн тоо мэдээлэл /хавсралт-1/	14

Зургийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Зураг 1	Бугат, Булган сумдын чацарганы талбай, хашаажуулалд	11
Зураг 2	Булган сумын чацарганы талбай, хашаажуулалд	11
Зураг 3	Баян-Агт, Орхон сумдын чацарганы талбай, хашаажуулалд	11
Зураг 4	Сэлэнгэ, хялганат тосгоны хүлэмж	11
Зураг 5	Сэлэнгэ сумын геррефорд бух, төл	12
Зураг 6	Малын хашаа тэрэг	13
Зураг 7	Хашаа, мотор	13
Зураг 8	Хашаа, хонь хяргах төхөөрөмж	14
Зураг 9	үр хадгалдаг сав, малын хээлтүүлэгчийн багаж	14

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд аймгийн Төрийн аудитын газрын 2021 оны “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-ний дагуу “Шинэ хөдөө төслийн хэрэгжилтийн үр дүн”-д гүйцэтгэлийн аудит хийлээ.
Аудитын зорилт	Шинэ хөдөө төслийн хэрэгжилтийн үр дүнд аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гарган холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ. Уг зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд: - Шинэ хөдөө төслийг төлөвлөхдөө хүртээмжтэй төлөвлөж худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу төлөвлөж зохион байгуулсан эсэх. - Шинэ хөдөө төслийн хүрээнд хийгдсэн арга хэмжээ, үйл ажиллагааны үр дүнг тооцож ажилласан эсэх. - Сумдаас төслийн хүрээнд хийгдсэн тайлан мэдээг цаг хугацаанд нь авч дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлсэн эсэх.
Аудитын хамарсан хүрээ	Булган аймгийн “Шинэ хөдөө-хөгжил” ОНӨААТҮГ, аймгийн ХХААГ, 2017-2020 оны төслийн төлөвлөгөө, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан ажлын тайлан, бусад байгууллагаас өгсөн зөвлөмж, түүний хэрэгжилтийн тайлан, холбогдох баримт материалууд, бусад холбогдох байгууллагын аудитын сэдэвт хамаарал бүхий үйл ажиллагааг хамрууллаа.
Аудитын хязгаарлалт	
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэхэд Гүйцэтгэлийн аудитын удирдамж АДБОУС 300, АДБОУС 3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт, гүйцэтгэлийн аудитын журмыг ашиглах бөгөөд шалгагдагч байгууллагын холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, холбогдох асуудлаар байгууллага ажлын хэсгийн ажилтнуудаас асуулга авах, судалгаанд дүн шинжилгээ хийх зэрэг аудитын горимыг хэрэгжүүлж асуудлын шинжилгээ, арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж аудитын дүн, дүгнэлт, зөвлөмжийг боловсрууллаа. Аудитын асуудлын шинжилгээг хавсралт-2, арга зүй матрицыг хавсралт 3-т тус тус үзүүлсэн.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр хянан удирдаж, менежер Ж.Энхцоодол үе шатны чанарын хяналтыг хийж, ахлах аудитор П.Мөнхтуяа, аудитор Б.Энхтөр, гэрээт аудитор Ш.Ууганжаргал нар хийж гүйцэтгэлээ. Аудитын удирдамжийн дагуу гүйцэтгэлийн аудитыг 2021 оны 10 дугаар сарын 25-ны өдрөөс 2020 оны 11 дугаар сарын 30-ны өдөр хүртэл гүйцэтгэж үе шатны хяналтыг хийлгэн, гүйцэтгэлийн аудитын тайланг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэн ажиллалаа.
Хүндрэл бэрхшээл	

А. Аймагт хэрэгжих төсөл арга хэмжээг төлөвлөхдөө сум, иргэдийн нэн тэргүүнд шаардлага үүссэн тоног төхөөрөмж болон мэргэжилтний судалгааг оновчтой гаргаж ажиллаагүй байна.

А.1. Шинэ хөдөө төслийн хүрэх үр дүн, зорилтыг төлөвлөж тооцоо судалгаа гаргаж дүгнэж төлөвлөжээ.

“Шинэ хөдөө хөгжил” ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаанд хамаарагдах төсөл нь анх аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 25 дугаар тогтоолоор “Булган жимс жимсгэнэ” хөтөлбөр нэртэйгээр батлагдан аймаг, орон нутгийн иргэдийн “Өрх, фермерийн аж ахуй болон жижиг хоршоод, иргэд жимс, жимсгэний аж ахуй эрхлэх замаар ажлын байр бий болгож, өрхийн орлогоо нэмэгдүүлэх, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, улмаар цөлжилтийг сааруулах, байгаль экологийн тэнцвэртэй байдлыг хадгалах” зорилготойгоор 2016-2020 онд хэрэгжихээр батлагдсан байна.

Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр гарах үр дүнг тооцоо судалгаанд үндэслэн 7 чиглэлээр тооцон дүгнэж төлөвлөсөн байна. Үүнд:

- Аймгийн дүнгээр нийт 2000 га-д жимс жимсгэнэ тариалагдсан байна.
- Жимс, жимсгэнэ тариалдаг бүл, өрхийн тоо одоогийнхоос 6-10 дахин нэмэгдэнэ.
- Ажлын байр 5000-аар нэмэгдэж, өрхийн орлого 1.5 сая төгрөгөөр нэмэгдэх
- Жимс, жимсгэнэ гоёл чимэглэлийн сөөглөг ургамлын цэцэрлэгт орчин бий болсноор хүмүүсийн амралт, чөлөөт цагийг үр ашигтай, тав тухтай өнгөрүүлэх орчин бүрдэн сум, орон нутгийн төв суурингийн тохижилт, цэцэрлэгжүүлэлт сайжирна.
- Жимс, жимсгэний болон чимэглэлийн сөөглөг ургамлыг тариалснаар ургамал ургах тааламжтай микро орчин үүсгэх ба энэ нь хөрсний ул усыг тодорхой түвшинд барих, салхины сөрөг нөлөө болон элсний нүүдлийг бууруулна.
- Хүнсний хэрэглээний нэр, төрөл нэмэгдэнэ.
- Жимс, жимсгэнэ тариалах сонирхолтой хүмүүсийг хамарсан чацарганы болон бусад сөөглөг ургамлыг арчилж, тариалах талаар сургалт явуулснаар мэргэшсэн ажилчид бэлтгэгдэнэ.
- Байгалийн зэрлэг жимс, жимсгэнийг зохистой ашиглах нөхцөл бүрдэнэ” гэсэн 8 чиглэлээр төлөвлөсөн байна.

Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийг 6 зорилтын, 21 ажлын 2018-2022 онуудад хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг тухайн жилийн байгаль, цаг уурын болон эдийн засгийн макро, микро орчны байдал, батлагдсан төсөв, зах зээлийн үнийн өсөлт зэргийг харгалзаж үзэхээр тогтоожээ.

А.2. Орлогыг 1553.6 мянган төгрөгөөр дутуу төлөвлөж, анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангаж ажиллаагүй, орлогын гүйцэтгэл 17 хувьтай байна.

“Шинэ хөдөө - Булган” дэд хөтөлбөрийн хүрээнд 2017-2020 онуудад байгаль, хамгаалах сан, УТХО-аар нийт 4141.0 сая төгрөгийн санхүүжилтээр төслийг хэрэгжүүлж ажиллажээ.

Шинэ хөдөө хөгжил төслийн санхүүжилтийн тоон мэдээллийг хүснэгтээр харуулбал:

/Хүснэгт-1/				мян/төг
№	Төслийн санхүүжилтийн төрөл	Тоо хэмжээ	Огноо	Санхүүжилтийн дүн
1	Байгаль хамгаалах сан	9	2017	1077011.6

2	УТХО	9	2018	976093.8
3	УТХО	17	2019	1657558.0
4	УТХО	3	2020	430350.0
Нийт дүн				4141013.4

Хүснэгтээс харахад нийт 3710.7 сая төгрөгийн хөрөнгийг “Шинэ хөдөө-хөгжил”-ын данс бүртгэлд бүртгүүлэхээр 2020 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 41 тоот тогтоол гарч уг тогтоолын дагуу байгууллагын санхүүгийн тайланд бүртгэж тайлагнасан байна.

“Шинэ хөдөө-хөгжил” ОНӨААТҮГ нь 2020 оны 05 дугаар сарын 27-ны 01 тоот ТУЗ-ийн тогтоолоор 9 орон тоогоор баталж, орлогын эх үүсвэрийг Түлүүгийн давааны ХАА-н бүтээгдэхүүн борлуулах цэгээс, Си-Ти 00-оос мөн үндсэн хөрөнгийн болон бусад төслийн эргэн төлөлтөөс орох орлогыг 210.8 сая төгрөгөөр төлөвлөжээ.

Төлөвлөгөө гүйцэтгэлийг хүснэгт 2-оор харуулбал:

				мян/төг
№	Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1	Хүлэмж	29290.0	19660.0	67.1
2	Чацаргана	142046.7	1296.9	0.9
3	Арьс элдэх тоног төхөөрөмж	2200.0	2200.0	100
4	Трактор	28800.0	4800.0	16.7
5	Павилон	8443.0	8443.0	100
Нийт дүн		210779.7	36399.9	17.2

Дээрх хүснэгтээс харахад орлогыг дутуу төвлөрүүлсэн нийт орлого 17.2 хувь эзэлж байгаа нь орлого оруулах тал дээр холбогдох иргэд, байгууллагатай хийсэн гэрээний дагуу ажилласан гэх боловч үр дүн бага гарснаар дүгнэгдэж байна.

Мөн орлогыг оновчтой зөв тодорхойлж ажиллаагүй, Си-Ти 00, гадна талбай зогсоолоос орох орлогуудыг төлөвлөгөөнд тусгаж батлуулаагүй байна.

Түлүүгийн давааны ХАА-н бүтээгдэхүүн борлуулах цэгийн павильоны, Си-Ти 00-оос 1193.6 буюу 2020 оны дансны хуулгаар тулгахад нийт 9793.6 мянган төгрөгийн орлого оржээ.

Үүнээс Си-Ти 00-оос 1193.6, гадна талбайн машины зогсоолоос 360.0 мянган төгрөгийн орлого тус тус орсон байна.

Орлогын гүйцэтгэлийг түүвэрлэн шалгахад анхан шатны баримтгүй зарцуулалт хийгдсэн, цалинг илүү, дутуу тооцсон, ажлын тайлан мэдээ байхгүй, цагийн бүртгэл хөтлөөгүй, бүрэн ажилласан нь тодорхойгүй байхад цалинг бүтэн бодож олгосон, орлогын бүртгэл бүрэн хөтлөөгүй, бэлэн мөнгөний зарцуулалтад тавигдах хянал сул зэрэг зөрчлүүд илэрлээ.

Тухайлбал: Түлүүгийн давааны ХАА-н бүтээгдэхүүн борлуулах цэг, Си-Ти 00, задгай талбайн бэлэн мөнгөний орлогоос 511,3 мянган төгрөгийн орлого дутуу, 408.8 мянган төгрөгийн бэлэн мөнгөний зарцуулалт дутуу, анхан шатны баримтгүй, тайлан мэдээ, цагийн бүртгэл хөтлөөгүй боловч зохицуулагчид 242,0 төгрөгийн цалин олгосон, ажилчдад 140.0 мянган төгрөгийн цалин илүү олгож, 126.0 мянган төгрөгийг дутуу суутгасан зөрчлүүд илэрч нийт 1428,1 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт бичлээ.

Дээрх зөрчлүүд нь НББ-ийн тухай хуулийн 13.6.¹, 13.7.² гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

¹ Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.

² Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно

Цаашид орлогыг зөв тодорхойлон төлөвлөж, анхан шатны баримтын бүрдлийг ханган ажиллаж, дотоод хяналтыг сайжруулж, үр дүнг тооцон ажиллах шаардлагатай байна.

А.3. Тендерийг хууль журмын дагуу зохион байгуулж ажилласан ч гүйцэтгэгчийг шалгаруулахдаа өмнөх ажлын үр дүнг тооцож ажиллах шаардлага үүсэж байна.

Аймгийн хэмжээнд 2017-2020 онуудад байгаль хамгаалах сан, УТХО-аар хэрэгжих төсөл арга хэмжээний ажлуудын тендер шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу зарлаж техникийн тодорхойлолтыг хийж, үнэлгээний хороо байгуулан гүйцэтгэгч, нийлүүлэгч компаниудыг сонгон шалгаруулж ажиллажээ.

Үүнд: Чацаргана төслийн хүрээнд 2017 онд чацарганы суулгац нийлүүлэх нийлүүлэгчээр 1, 2-р багцад УБ хотын “Хаан жимс эс би ти” ХХК-тай 183093.7, 3, 4-р багцад Өвөрхангай аймгийн “Хархорин” ХХК-тай 193750.0 мянган төгрөгөөр тус тус гэрээ байгуулан, гэрээний нөхцөлийн дагуу чацарганыг нийлүүлэн ажилласан байна.

Мөн 2019 онд УТХО-аар нийт 2.0 тэрбум төгрөг батлагдаж 18 багц ажилд, мөн 2020 онд 4 төрлийн 480300.0 мянган төгрөгийн багц ажлуудын тендерийг зарлаж сонгон шалгаруулалт хийгдэж нийлүүлэгч компаниудыг сонгон шалгаруулж, гэрээ байгуулан ажиллажээ.

Улсын төсвийн 2019 оны хөрөнгө оруулалт, хэрэгжилтийн үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитаар 18 багц төсөл арга хэмжээний тоног төхөөрөмж, техник хэрэглэлүүдийг нийлүүлэх гүйцэтгэгч зарим нэг компани нь гэрээний дагуу хугацаандаа нийлүүлээгүй, тоног төхөөрөмжийн хэрэгсэл дутуу, дараа нь гүйцээж өгнө гэсэн тайлбартай, тухайн үед томилогдсон ажлын хэсэг тоног төхөөрөмж хүлээж авснаар акт үйлдсэн зэрэг зөрчлүүд илэрч байсанд төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж хүргүүлэн ажилласныг дүгнэхэд төсөл арга хэмжээний сонгон шалгаруулалтад гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа гүйцэтгэгч компаний өмнөх ажлын үр дүнг дүгнэн үзсэнээр сонгон шалгаруулалтад оруулж байх шаардлагатай байна.

Б.Шинэ хөдөө төслийн хүрээнд хийгдсэн арга хэмжээ, үйл ажиллагаа нь үр дүн бага байна.

Б.1. Түрээсийн гэрээ хийсэн иргэд эргэн төлөлтөө хугацаандаа хийгээгүй, иргэнтэй гэрээ хийж ажиллаагүй, авлага 13 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь найдваргүй авлага үүсэх магадлалтай байна.

Шинэ хөдөө төслийн 2018-2020 онуудад хэрэгжсэн чацаргана, бух, хуц, холбогдох тоног төхөөрөмжийн 3710,6 сая төгрөгийн хөрөнгөөс үндсэн хөрөнгийг түрээсээр, эргэлтийн бус 1285,2 сая төгрөгийн хөрөнгийг эргэн төлөлтийн гэрээ байгуулж авлагаар тусгаж ажиллахаар 2020 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 41 дүгээр тогтоолын шийдвэр гарчээ.

Уг тогтоолын дагуу үндсэн хөрөнгө, эргэлтийн бус хөрөнгүүдийг авлагаар тусган гэрээг байгуулан ажилласан гэх боловч иргэдтэй гэрээ хийгдээгүй, зарим тоног төхөөрөмжийг эзэнжүүлээгүй, сумдын ЗДТГ-т хадгалагдаж байна.

Үүнийг хүснэгтээр 3-аар харуулбал:

мян/төг

№	Төслийн төрөл	Гэрээ хийгдээгүй иргэдийн тоо	Тоо/ш	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Чацаргана	18	2000	2000	4000.0
2	Хашаа /чацарганы/	18	0	0	2096.3
3	Дуслын усалгааны систем	18	0	422.9	7612.0
Дүн		18			13708.3
Сумдын ЗДТГ-т хадгалагдаж байгаа үндсэн хөрөнгийн жагсаалт					

1	Арьс төхөөрөмж	эдлэх	3	3	8500.0	25500.0
2	Жимс, хатаагч	ногооны	1	1	5400.0	5400.0
Дүн			4			30900.0
Нийт дүн						44608.3

Дээрх хүснэгтээс харахад авлагаар бүрэн тусгаж тайлагнасан боловч одоог хүртэл гэрээ байгуулж ажиллаагүй байгаа нь ажлын үр дүн, найдваргүй авлага үүсэх эрсдэлийг дагуулж байна.

Иймд 44608.3 мянган төгрөгийн хөрөнгийг эзэнжүүлж ажиллаагүй, гэрээ хийгдээгүй зөрчилд албан шаардлага бичлээ.

Мөн зөгийн бүлийн иж бүрдэл бүхий 9289.8 мянган төгрөгийн 28 тооны дагалдах хэрэглэлийг хүлээн авсан, иргэдэд олгосноор нь тулгахад 6 тооны 1990.7 мянган төгрөгийн дагалдах хэрэгсэл бүхий хувцас дутуу ирсэн, 22 тооны иж бүрдлийг олгож эргэн төлөлтийн гэрээ хийсэн, тухайн үед сумдын холбогдох мэргэжилтэн даргаар хүлээн авснаар гарын үсэг зуруулж бүрэн хүлээн авснаар акт үйлдсэн зэрэг зөрчил илэрлээ.

Иймд зөгийн бүлийн дутуу иж бүрдлийг нийлүүлсэн компаниас нөхөж авахаар албан тоот авхуулж нотлох баримтыг бүрдүүлэн, тухайн үед ажлын хэсэгт ажилласан албан хаагчдад 1990.7 мянган төгрөгийн зөрчилд хариуцлага тооцох албан шаардлага бичлээ.

Тухайн байгууллага нь нийт эргэлтийн хөрөнгийн 1285223.2 мянган төгрөгийн авлагаас 2020 онд 214895.0, түрээсийн орлогоос 28800.0 мянган төгрөгийн орлогыг тус тус төлөвлөж, гүйцэтгэлээр эргэлтийн хөрөнгийн авлагаас 20956.9, түрээсийн орлогоос 4800.0 мянган төгрөг буюу нийт 27956.9 мянган төгрөгийн орлого оржээ.

Энэ нь тухайн жилд орох орлогын 13 хувийг эзэлж байгаа нь авлага бүрэн барагдахгүй, найдваргүй авлага үүсэх магадлалтай байна.

Цаашид гэрээ хийсэн иргэдээс эргэн төлөлтийг бүрэн оруулж байх арга хэмжээг авч ажлаа сайжруулах шаардлагатай байна.

Б.2 Шинэ хөдөө төслөөр хэрэгжсэн төслийн үр дүн, ашиг шимийг тооцож ажиллаагүй, ИТХ-ын тогтоол, шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй, одоог хүртэл ашиглагдаагүй тоног төхөөрөмжүүд байгаа нь төсөл үр дүнгүй байна.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн “Хөрөнгө бүртгэлд авах тухай” 41 дүгээр тоот тогтоол гарч уг тогтоолын 1 дүгээр хавсралтаар “Шинэ хөдөө-хөгжил” ОНӨААТҮГ-ын данс бүртгэлд авах хөрөнгийн, 2 дугаар хавсралтаар сумдын ЗДТГ-ын данс бүртгэлд авах хөрөнгийн жагсаалтыг тус тус гаргасан байна.

Тус тогтоолын хэрэгжилтийг үзэхэд 2017-2020 онуудад, чацаргана, хүлэмж, хээлтүүлэгч мал, худаг, тоног төхөөрөмж нийлүүлсэн төсөл арга хэмжээ хэрэгжилтийг түүвэрлэлтээр үзэхэд зарим төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжиж, зарим нь дутуу буюу ашиглагдаагүй тоног төхөөрөмжүүд одоог хүртэл хадгалагдаж байгаа, бүх сумын хүрээнд сумын ЗДТГ-т 2017 оны усалгааны систем авч бэлтгүүлэхээр байгаль хамгаалах сангаас 63270.0 мянган төгрөг олгосноор тогтоолын хавсралтыг бэлтгэсэн, зарим сумд нь чацарганы усалгааны систем аваагүй санхүүжилтээ татуулсан, зарим нь анхан шатны баримтын бүрдэлгүй, баримтгүй зэрэг зөрчлийг арилгах албан шаардлага бичлээ.

Тухайлбал: Чацарганы суулгацыг 17 сумын хэмжээнд түүвэрлэн 9 сумын ургацыг үзэхэд Сэлэнгэ, Булган, Хангал, Тэшиг, Баян-Агт, Хутаг-Өндөр сум, Хялганат тосгоны 2020 оны байдлаар 10-40 хувь ургасан байхад Бугат, Орхон сумдын чацарганы ургалт 10 хүрэхгүй хувь буюу маш бага байгаа нь чацарганы хашаа муу баригдсан, иргэд малаа хашаанд оруулсан, 2017-2018 онуудын чацарганы суулгацыг оройтуулж олгосон, тухайн жилүүдэд ган гачигтай жил байсан зэргээс шалгтаалсан тухай иргэд хэлж байсан.

Аудитад хамрагдсан чацарганы талбай, хашааны зургийг зургаар харуулбал:

Бугат сум



Булган сум

/зураг-1/



Булган сум

/зураг-2/



Баян-Агт сум

Орхон сум

/зураг-3/



Сумдын иргэдэд нийт 101 ширхэг 4x8 хэмжээтэй буюу 32 мкв хүлэмжийг 1,178.0 мянган төгрөгийн эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр тарааж өгснөөр иргэд улаан, ногоон чинжүү, огурци тариалж өрхийн хэрэгцээндээ болон өрхийн орлогоо нэмэгдүүлж үр дүнг үзэж сэтгэл хангалуун байгаагаа илэрхийлж байсан.

/Сэлэнгэ сум, Хялганат тосгоны хүлэмж/

/зураг-4/



Шинэ хөдөө төслийн хүрээнд Хангал суманд 2019 онд олгосон 25,993.0 мянган төгрөгийн 75 бүл зөгийг 8 иргэнд олгож 2021 оны хавар өвөлжүүлсэн зөгийг гаргахад хорогдсон байсанд сумаас ажлын хэсэг гарган хорогдсон шалтгааныг тогтоолгохоор Мал эмнэлгийн газарт зөгийнөөс стандартын дагуу дээж авхуулах хүсэлт явуулсны дагуу Улсын мал эмнэлгийн төв лаборатори “Зөгийн лаборатори”-ийн шинжилгээ хийхэд аспергиллуссын төрлийн мөөгөнцөр илэрч эерэг гарч иргэд зөгийн байрыг стандартын дагуу янзлаагүйгээс мөөгөнцөр үүсэж зөгий үхэхэд хүрсэн, мөн зөгийн бүл болон зөгийн дагалдах багаж хэрэгсэл зээлээр олгох гэрээний 2 дугаар зүйлийн 2.3³ дахь заасны дагуу зээлдүүлэгч тал гэрээгээ бүрэн биелүүлж ажиллаагүй, мөн тус гэрээнд заасны дагуу зээлдэгч тал гэрээний 3 дугаар зүйлийн 3.3⁴, 3.4⁵ дэх заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй тул эргэн төлүүлэхээр албан шаардлага бичлээ.

Сэлэнгэ сумын хээлтүүлэгч Сэлэнгэ-Герефорд үүлдрийн бух 2019 онд олгосон 91149, 2018 онд олгосон 737139 чихний тус тус ээмэгний дугаартай 2 тооны 8300.0 мянган төгрөгийн үнэтэй бух, Хялганат тосгоны Сэлэнгэ үүлдрийн 2018 онд олгосон 1650.0 мянган төгрөгийн үнэтэй 1 бух нийт 9950.0 мянган төгрөгийн 3 бух хорогдсоныг одоо болтол ямар шалтгаанаар хорогдсоныг малын эмчийн тодорхойлолтгүй, акт болон бусад нотлох баримтгүй тул албан шаардлага бичлээ.

/Сэлэнгэ сумын герефорд бух, төл/

/зураг-5/



Мөн Бугат суманд 2018 онд Сэлэнгэ үүлдрийн бух хүлээн авсан иргэн гэрээний үүргийн дагуу бухын түрээсийн төлбөр болох тугалыг хүлээлгэн өгөхөөр бэлдсэн боловч “Шинэ хөдөө-хөгжил” ОНӨААТҮГ-аас ирж төлбөрөө тооцож авахгүй байна гэсэн санал ирүүлсэн.

“Шинэ хөдөө-хөгжил” ОНӨААТҮГ нь 2020 оны 4 дүгээр сард аймгийн Засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсэгтэй хамтран, 2017-2019 онуудад “Шинэ хөдөө” төслөөр сумдад төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн хөрөнгийг хүлээн авч бусад хөрөнгийн ашиглалт хамгаалалтад дотоодын хяналтыг давхар хийж явсан боловч нэг бүрийн үнэ нь 7500 төгрөг, 6000 ширхэг буюу нийт 45,0 сая төгрөгийн үнэтэй гүн хөлдөөсөн үрийг Сэлэнгэ аймгийн Зүүн-бүрэн суманд байдаг “Газар агро” ХХК-ий лабораторид байгаа үрийг тухайн үед томилолтын хугацаа хоногоос шалтгаалан очиж үзээгүй, одоо болтол ашиглаагүй боловч байгууллагын санхүүгийн тайланд орлого авч бараа материалын тодруулга тайланд бүртгэж тайлагнасан зөрчил илэрсэн тул албан шаардлага бичлээ.

Сумдад тараагдсан тоног төхөөрөмжүүдээс 150400,0 мянган төгрөгийн хонь хяргах хайч, хашаа, чирэгч тэрэг, цахилгаан эх үүсгэвэр бүхий мотор, зохиомол хээлтүүлэг хийх 54519,4 мянган төгрөгийн багаж тоног төхөөрөмжүүд зарим сумдад одоог хүртэл ашиглаагүй хадгалагдаж байна.

³ Тухайн зөгийн бүл, дагалдах багаж төхөөрөмжийн ашиглалт, бүрэн бүтэн байдал болон гадна өнгө үзэмжид байнгын хяналт тавина.

⁴ Зээлдэгч гэрээгээр хүлээсэн үүргээ ноцтой зөрчих, зээлээр эзэмшиж буй зөгийн бүл, багаж төхөөрөмжөө зориулалт бусаар ашиглах, бусдад хууль бусаар шилжүүлэх, төлбөрийн чадваргүй болох, эд хөрөнгө эзэмших чадваргүй болсон тохиолдолд зээлдүүлэгч гэрээг дангаараа цуцлах эрхтэй бөгөөд, учирсан хохирлыг зээлдэгч төлөх үүрэгтэй.

⁵ Зээлдсэн зөгийн бүл, дагалдах багаж хэрэгслийг гэрээнд заасан зориулалтаар нь эзэмшиж, ашиглах бөгөөд бүрэн бүтэн байдлыг хариуцна.

Мөн нэг сумаас нөгөө сум, байгууллага руу тоног төхөөрөмжийг шилжүүлэхдээ хөрөнгө хүлээлцсэн акт үйлддэггүй, хүлээн авсан газар нь орлого аваагүй, худгийн мотор, усны нөөцийн сав алдагдсан зэрэг зөрчлүүд илэрч байна.

Үүнийг сумдын ЗДТГ-т хүлээлгэн өгсөн хонь хяргах хайч, хашаа, чирэгч тэрэг, мотор зэрэг нь айлын байшинд, зарим хашааг нь өвс, ногооны хашааны хаалтаар ашиглаж, зарим тоног төхөөрөмж нь грашд, зарим нь ЗДТГ-т хадгалагдаж байгааг мэргэжлийн зоо техникч байхгүйтэй холбон үзэж байна.

Мөн суманд нэн тэргүүнд шаардлагатай тоног төхөөрөмжийн судалгааг оновчтой гаргаж өгөөгүйгээс төслийн хөрөнгийг үр дүнгүй зарцуулсан гэж дүгнэхэд хүргэж байна.

Тухайлбал: Булган сумын нисэх онгоцны буудлын хажууд байрлах 11 иргэний 2.2 га талбайн худгийн мотор, хадан хошууны 5 иргэний 1.6 га талбайн худгийн ус нөөцлөх сав алдагдсан тул холбогдох иргэдээр төлүүлэх албан шаардлага бичлээ.

Хадгалагдаж байгаа тоног төхөөрөмжийн зургийг зургаар илэрхийлбэл:

Малын хашаа тэрэг

/зураг-6/



Хашаа, мотор

/зураг-7/



Хашаа, хонь хяргах төхөөрөмж

/зураг-8/





Ихэнх сумд нь дээрх тоног төхөөрөмжүүдийг ашиглаагүй, хадгалагдаж байна.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 41 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар олгосон 27515.6 мянган төгрөгийн үнэтэй “Нарны эрчим хүч бүхий худаг”-ийг Тэшиг сумын ЗДТГ орлого аваагүй, ашиглаагүй, хаана, хэн, хэзээ хүлээлгэн өгсөн нь тодорхойгүй зөрчил илэрсэн тул албан шаардлага бичлээ.

Мөн Баян-Агт, Бугат сумын ЗДТГ-т хадгалагдаж байсан 2018 оны 29903.5, 2019 онд олгосон 23385.7 буюу нийт 53289.2 мянган төгрөгийн дуслын усалгааны системийг ХТҮА-руу шилжүүлсэн боловч уг хөрөнгийг орлого аваагүй зөрчлүүд илэрсэнд албан шаардлага бичлээ.

Байгаль хамгаалах сангаас олгосон усалгааны систем авах 53520.0 мянган төгрөгийн гүйцэтгэлийг үзэхэд тоног төхөөрөмжийг худалдан авалт хийгээгүй санхүүжилтийг оны эцэст татан төвлөрүүлсэн, зарим сумд нь тоног төхөөрөмжийг орлогод аваагүй, санхүүжилтээр юу авсан нь тодорхойгүй, анхан шатны баримгүй зөрчлүүд илэрсэн.

Санхүүжилтийн дүнг хавсралтаар хүснэгт-4 харуулсан болно.

Хүснэгтээс харахад Сэлэнгэ сумын ЗДТГ нь усалгааны систем авахаар 8000.0 мянган төгрөгийн санхүүжилт авч гүйцэтгэлээр татварт 800.0 мянган төгрөг шилжүүлж 6270.0 мянган төгрөгөөр усалгааны систем авсан анхан шатны баримттай, 930.0 мянган төгрөгөөр юу авсан нь тодорхойгүй зөрчил илэрсэнд төлбөрийн акт бичлээ.

Дээрх зөрчлүүдийг дүгнэн үзэхэд сумдын ЗДТГ-т хадгалагдаж байгаа хөрөнгө хуучирч муудах, зарим тоног төхөөрөмж дутагдах, эзэмших эзэндээ очиход шаардлага хангахааргүй болох магадлалтай, мөн дотоод хяналт алдагдсан, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажилладаггүй, ажлын хариуцлагаас шалтгаалан гарсан гэж дүгнэлээ.

В. Бүлэг: Сумдаас төслийн хүрээнд хийгдсэн ажлын тайлан мэдээг цаг хугацаанд нь авч дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

В.1. “Шинэ хөдөө-хөгжил” ОНӨААТҮГ нь үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш төслийн хүрээнд хийгдсэн ажлын тайлан мэдээг сумдаас хүлээн авч ажиллаагүй байна.

Санхүүгийн тайлан мэдээг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйл, ОУНББ-ийн стандартын дагуу тайлан мэдээг гарган ажиллаж байгаа ч “Шинэ хөдөө-хөгжил” ОНӨААТҮГ нь төслөөс тараагдсан хөрөнгийн ашиглалт хамгаалалт, үр дүнг тооцсон үйл ажиллагааны тайлан мэдээг гаргуулж авдаг хууль журам, стандартыг ашиглаагүй, шаардлагатай үед утсаар холбогдож мэдээллээ авч ажиллаж байна.

“Шинэ хөдөө-хөгжил” ОНӨААТҮГ нь үйл ажиллагааны тайланг 2020 оны жилийн эцсээр болон 2021 оны хагас жилээр гаргасан боловч тайланд төслийн хүрээнд хийгдсэн

ажлыг дүгнэж, үр дүнг тооцсон мэдээлэл байхгүй, 2017-2019 онд төслийн үйл ажиллагааны тайлан мэдээ гаргаж байгаагүй байна.

Цаашид сумдад хэрэгжиж байгаа төслийн хэрэгжилтийн тайлан мэдээг холбогдох мэргэжилтнүүдээс авч байхаар хамтарч ажиллах шаардлагатай байна.

В.2 Хяналт шалгалтаар илэрсэн алдаа зөрчил одоог хүртэл шийдвэрлэгдээгүй, арилаагүй байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны 5 дугаар сарын 04-ний өдөр баталсан удирдамжийн дагуу 2017-2019 онд хэрэгжсэн “Шинэ хөдөө-Булган” дэд хөтөлбөрийн хүрээнд сумдад олгосон төмс хүнсний ногооны тоног төхөөрөмж, чацарганы суулгац, хашаа, дуслын усалгааны систем, малын удмын сан, ашиг шимийг нэмэгдүүлэх цөм сүрэг бүрдүүлэх зорилгоор олгосон герефорд, Сэлэнгэ үүлдрийн бух, дархад, баяд, цагаан уул үүлдрийн хуц, эрчим үүлдрийн ухна, хүлэмж, зөгийн бүл зэргийг тоолж хүлээж авах, гурвалсан гэрээ байгуулах, баримтжуулах, акт үйлдэх зэрэг ажлаар 3 чиглэлээр зохион байгуулахаар ажлын хэсэг гарч ажиллажээ.

Хяналт шалгалтаар Баяд үүлдрийн 135 хуц, Эрчмийн хар үүлдрийн 245 ухна маллуулахаар Хутаг-Өндөр сумын иргэнтэй гэрээ хийсэн боловч газар дээр нь очиж үзэхэд бэлчээрээр маллах шалтгаанаар, Бүрэгхангай суманд туслан гүйцэтгэгчийг сонгож “Баяд үүлдрийн” 160 хуц нийлүүлэхээр гэрээ байгуулсан боловч хуцын мөнгө дутуу орж ирсэн шалтгаанаар тус тус дутаасныг гэрээ хийсэн дүнгээр хуулийн хяналтын байгууллагад шилжүүлсэн нь шийдвэрлэгдээгүй байна.

Хяналт шалгалтаар илэрсэн алдаа зөрчлүүд нь анх төслийн багийн гишүүд болон ажлын хэсэгт үүрэг болгон өгсөн ч ажил үүргээ бүрэн биелүүлээгүй, хяналт сулаас шалтгаалан алдаа зөрчлүүд давтагдан гарч байна.

В.3 Хяналт шалгалтын байгууллагаас өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг тооцож байгаа ч бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Санхүүгийн тайлан баталгаажуулалтаар 9 зөвлөмж, 2 албан шаардлага хүргүүлж ажилласан ч алдаа зөрчил мөн адил давтагдаж байна.

Үүнд: Санхүүжилтийн зарцуулалтаар анхан шатны баримт дутуу, төсөлд хамрагдсан иргэдтэй бүрэн гэрээ байгуулж ажиллаагүй дутуу, хадгалагдаж байгаа хөрөнгийг эзэнжүүлж ажиллаагүй, хөрөнгийн хөдөлгөөнд тавих хяналтыг сайжруулж ажиллаагүй байна.

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

- Шинэ хөдөө төслийн хүрэх үр дүн, зорилтыг төлөвлөж тооцоо судалгаа гаргаж ажилласан ч иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцээгүй байна.
- Орлогыг дутуу төлөвлөж, анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангаж ажиллаагүй, төлөвлөсөн орлогын гүйцэтгэл 17 хувьтай.
- Төслийн гүйцэтгэгчийг шалгаруулахдаа өмнөх ажлын үр дүнг тооцож ажиллах шаардлага үүсэж байна.
- Авлагын гүйцэтгэл 13 хувьтай байгаа нь найдваргүй авлага үүсэх магадлал их байна.
- Чацаргана төсөлд хамрагдсан 18 иргэдтэй 44608.3 мянган төгрөгийн гэрээг хийгээгүй.
- Иргэдтэй анх хийсэн гэрээний нөхцөлийг өөрчилснөөр маргаан үүсэх магадлалтай байна.
- Эзэнжүүлээгүй тоног төхөөрөмж айл, өрх болон сумдын ЗДТГ-т хадгалагдаж байгаа нь бүтээмж муутай, өндөр үнэтэй тоног төхөөрөмж нийлүүлсэнтэй холбоотой байна.
- ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолын хэрэгжилт хангалтгүй, алдаа зөрчил илэрсээр байна.
- Төслийн хэрэгжилтэд хяналт шалгалтыг хийж ажилласан ч зарим төсөл арга хэмжээ нь үр дүнгүй байна.

- Гэрээ хийсэн иргэд 9950.0 мянган төгрөгийн 3 бухыг хорогдуулсан.
- Хялганат тосгоны 4 өрхийн 40 бүл бүхий 25993.0 мянган төгрөгийн зөгий үхсэн.
- Булган сумын чацарганы талбайн худагын мотор болон ус нөөцлөх сав хулгайд алдагдсан.
- Түүвэрлэлтэд хамрагдсан 9 сумын чацарганы ургац 10-40 хувьтай ургасан нь ургац хангалтгүй үзүүлэлтэй.
- Зөгийн бүлний 6 ш дагалдах хэрэгслийг дутуу нийлүүлсэн.
- Гүн хөлдөөсөн 45000.0 сая төгрөгийн үрийг бодитой хүлээж аваагүй хэрнээ бараа материалын тодруулга тайланд бүртгэсэн.
- Үндсэн хөрөнгийн шилжилт хөдөлгөөний бүртгэлийг бүрэн хөтлөөгүй.
- Хяналт шалгалтаар өгсөн үүрэг даалгавар, албан шаардлагын биелэлт болон төслийн хэрэгжилт хангалтгүй гэж дүгнэлээ.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.

Үүнд:

Нэг: Аймгийн ИТХ-ын дарга Д.Эрдэнэбатад:

1. Төслийн хэрэгжилттэй холбогдон гарсан тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж хэрэгжилтийг тооцох.

Хоёр. Аймгийн Засаг дарга Б.Ариун-Эрдэнэд:

1. Шинэ хөдөө төслийн хэрэгжилт болон ажлын хэсгийн бүрэлдэхүүний ажилд тавих хяналтыг сайжруулж, хэрэгжилтийн үр дүнгийн тайланг авч тооцож ажиллах.
2. Сумдын ЗДТГ-т ашиглагдахгүй, эзэнжүүлээгүй, орлогод аваагүй хөрөнгийг нэг бүрчлэн бүртгэх ажлыг зохион байгуулж хэрэгжилтийн үр дүнг тооцох.

Гурав: “ХААХИ” ОНӨХХК-ий захирал Ш.Өлзийхутаг, нягтлан бодогч Д.Ганцэцэг

нарт:

1. Жилийн орлогыг бүрэн тусгаж, зардлыг оновчтой тооцон, санхүү, үр ашгийн төлөвлөгөөг батлуулж ажиллах.
2. Найдваргүй авлага үүсэхээс сэргийлэх арга хэмжээг авч авлагыг бүрэн төвлөрүүлж ажиллах.
3. Гэрээнд заасан 2 талын үүрэг хариуцлага, дотоод хяналтыг сайжруулах
4. Сумдын мэргэжилтнүүдтэй хамтран ажиллаж төслийн хэрэгжилтийн тайлан мэдээг авч ажиллах.

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.АНХБАЯР
Ж.ЭНХЦООДОЛ

АУДИТЫН ТАЙЛАН БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

П.МӨНХТУЯА
Б.ЭНХТӨР



БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2021 оны 12 сарын 15 өдөр

Дугаар 123

Булган

Гүйцэтгэлийн аудитын тайлан
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.4 Монгол Улсын Ерөнхий аудиторовн 2018 оны 11 дүгээр сарын 19-ны өдрийн А/207 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 1.1, 1.3, 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журмын -ын 18.9-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Төрийн аудитын байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө"-ний дагуу "Шинэ хөдөө төслийн хэрэгжилтийн үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан, төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийг хавсралтаар баталсугай.
2. "Шинэ хөдөө төслийн хэрэгжилтийн үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг аймгийн ИТХ, Засаг дарга, "ХААХИ" ОНӨХХК-д хүргүүлсүгэй.
3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2022 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлэхийг аймгийн ИТХ-н дарга Д.Эрдэнэбат, Засаг дарга Б.Ариун-Эрдэнэ, ХААХИ" ОНӨХХК-ий захирал Ш.Өлзийхутаг нарт зөвлөсүгэй.
4. Аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хугацаанд нь хангуулж, биелэлтийг тооцон хяналт тавьж ажиллахыг аудитын менежер /Ж.Энхцоодол/-д даалгасугай.
5. Аудиттай холбоотой ажлын болон нотлох баримтыг тайлан баталгаажуулснаас хойш 14 хоногийн дотор архивын нэгж болгон хүлээлгэн өгөх, Төрийн аудитын байгууллагын цахим хуудсанд байршуулж, олон нийтэд түгээхийг ахлах аудитор /П.Мөнхтуяа/-д үүрэг болгосугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



D: /bnchig hereg/2021/tushaal/TAtushaal.doc

006010094

23



**БУЛГАН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУУЛЫН ТЭРГҮҮЛЭГЧИД**

63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг
Цогт Хунтайжийн талбай
Утас: 7034-2856 Факс: 7034-2856

2021 12.14 № 2/206

Танай _____ -ны № _____ -т

**БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ**

“Шинэ хөдөө төслийн хэрэгжилтийн үр дүн”-д
хийсэн гүйцэтгэлийн аудитын /БУА-2021/05/-ШТА-
ГА/ дугаартай тайлангийн төслийн төсөлд өгөх
саналгүй байна.



НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ М.БАТЖАРГАЛ

Doc.toot a5 2021

24


МОНГОЛ УЛС
БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг
Хунтайжийн талбай, Утас: 7034-2680
E-mail: azdtgbulgan@gmail.com
http://www.bulgan.gov.mn

2021.12.19 № 01/418
танын 2021.12.10 -ны № 209 -т

┌ **БУЛГАН АЙМАГ ДАХЬ** ┐
└ **ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ** ┘

"Шинэ хөдөө төсөл"-ийн хэрэгжилтийн үр дүнгийн
аудитын тайланд нэмж хүргүүлэх санал байхгүй байна.



ЗАСАГ ДАРГА  Б.АРИУН-ЭРДЭНЭ

22



**“ХӨДӨӨ АЖ АХУЙ-ХӨГЖЛИЙН ИРЭЭДҮЙ”
ХХК**

63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг
Регистр: 3197956, Утас: 9427-9717
И-мэйл хаяг: Khugjila.ireedu2021@gmail.com

2021.12.13 № 64
тнай _____-ны № _____-т
Г _____ Г

**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

“Шинэ хөдөө төслийн хэрэгжилтийн үр дүн”-д
хийсэн гүйцэтгэлийн аудитын /БУА-2021/05/-ШТА-ГА
дугаартай тайлангийн төсөлтэй танилцлаа.
Эдгээрт дурдсан зөрчил дугтагдлыг засч,
цаашид гаргахгүй байхад анхаарч ажиллах болно.

Таныг хүндэтгэсэн:

ЗАХИРАЛ  ШӨЛЗИЙХУТАГ